

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг
тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн
шугамын ашиглалт эхэллээ**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Өнгөрсөн хугацаанд Уул уурхайн яамнаас жижиглэнгийн шатахууны зах зээлийн тооцоо, судалгааг гүйцэтгэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нефтийн компаниудын нэрс, олгох санхүүжилтийн дүнг тооцоолох, Монголбанкнаас банкуудтай зээлийн шугамын гэрээ, санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглах гэрээ байгуулах, **6 оролцогч банкны** зүгээс хэрэгжүүлэгч **13** компанийн зээлийн судалгааг гүйцэтгэх, хоёр төрлийн гэрээ байгуулах зэрэг ажлууд тус тус гүйцэтгэснээр зээлийн шугамыг ашиглах нөхцлийг бүрдүүллээ.

Энэ хүрээнд дэд хөтөлбөрийн анхны транчаар хөтөлбөрт оролцогч банкинд жилийн **3.8%**-ийн хүүтэй, **1** жилийн хугацаатай **7.1** тэрбум төгрөгийн зээлийн шугамыг нээж, хэрэгжүүлэгч “Жаст Ойл” ХХК нь уг эх үүсвэрийг шатахууны импортын гадаад төлбөрт зориулан **2012 оны 11 дүгээр сарын 27-ны** өдөр ашиглалаа.

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан “Жаст ойл” ХХК-д **7.1** тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг **2** сарын дараа худалдах форвард хэлцлийг **хамгийн бага зардлаар** гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Дэд хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтворжуулах хөтөлбөр” цэснээс үзнэ үү. <http://www.mongolbank.mn/pricestability.aspx>